



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/529

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинэ төгс шийдэл" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Цэцэрлэгийн барилгын засвар /Ховд, Жаргалант сум, 10 дугаар цэцэрлэг/-н ажилд ашиглагчийн хүсэлтийн дагуу ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдэх ажлыг нягтлан шалгаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Өлзийбаяр

- 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Ш.Дамдинсүрэн

- "Шинэ төгс шийдэл" ХХК-ийн захирал


Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 2667
Zah A/529 Kh